

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2025.04.21**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- CNBC агентлагийн хамгийн сүүлд явуулсан "Америкийн Бүх Ард Түмний Эдийн Засгийн Судалгаа"-ны үр дүнгээр, Ерөнхийлөгч Дональд Трампын эдийн засгийн бодлогын дэмжлэг түүний ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд хамгийн доод цэгт хүрээд байна.
- Инфляцтай тэмцэх Трампын бодлогыг 60–37-ийн харьцаагаар олон нийт шүүмжилж байна. Энэ асуудал нь Бүгд Найрамдах намын дунд хүртэл хамгийн сул дэмжлэгтэй сэдэв болж, ердөө 58% нь зөвшөөрч байна.
- Өмнөд хилийн хамгаалалтын бодлогыг 53–41%-ийн харьцаагаар дэмжиж байна.
- Албадан гаргалтын бодлогыг 52–45%-ийн харьцаагаар дэмжжээ.
- БНХАУ-ын Төв банк (PBOC) даваа гарагт зах зээлийн хүлээлттэй нийцүүлэн зээлийн суурь хүүгээ (Loan Prime Rate, LPR) тогтвортой хадгаллаа.



### S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
<b>Дундаж</b>	<b>6,678</b>







## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.04.14-04.20

## ДОНАЛЬД ТРАМПЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ ТҮҮХЭН ДООД ТҮВШИНД ХҮРЛЭЭ

CNBC агентлагийн хамгийн сүүлд явуулсан "Америкийн Бүх Ард Түмний Эдийн Засгийн Судалгаа"-ны үр дүнгээр, Ерөнхийлөгч Дональд Трампын эдийн засгийн бодлогын дэмжлэг түүний ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаанд хамгийн доод цэгт хүрээд байна. Олон нийт түүний тариф, инфляц болон төрийн зарлагын бодлогыг илүү их шүүмжлэх болсон нь энэхүү уналтад нөлөөлжээ. Судалгааг 4-р сарын 9–13-ны хооронд 1,000 америкчуудын дунд хийсэн бөгөөд Трамп дахин сонгогдсоноос хойш эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн талаархи өөдрөг хандлага эрс суларсныг харууллаа. Түүний нийт ажлын гүйцэтгэлийг 44% нь дэмжиж, 51% нь дэмжээгүй байна. Энэ нь CNBC-ийн судалгаанд анх удаа Трамп эдийн засгийн асуудлаар цэвэр сөрөг үнэлгээ авч буй тохиолдол болов. Тодруулбал:

- Америкчууд өргөн хүрээний тарифыг 49–35 харьцаагаар эсэргүүцэж байна. Олонх нь тарифыг ажилчдад сөргөөр нөлөөлдөг, инфляцыг нэмэгдүүлдэг, эдийн засгийг доройтуулдаг гэж үзжээ.
- Бүгд Найрамдах намын дунд хүртэл тарифын дэмжлэг 20 нэгжээр бага байгаа нь анхаарал татаж байна (Трампыг 79%, тарифыг 59% дэмжиж байна).
- Ардчилсан намын дэмжигчид тарифыг 83 оноогоор няцааж, бие даагчид 26 онооны сөрөг үнэлгээ өгчээ.

Америкчуудын олонх нь Канад, Мексик, Европын Холбоо, Япон зэрэг орнуудыг эдийн засгийн түншүүд гэж харж байгаа нь Трампын түрэмгий худалдааны бодлогыг олон нийт хангалттай дэмждэггүйг илтгэж байна. Харин Хятад улс бол өөр хэрэг: 44% нь Хятадыг эдийн засгийн аюул гэж үзэж байгаа бол 35% нь боломж гэж харж байна.

**Инфляцтай тэмцэх бодлого — хамгийн сул үзүүлэлт**

Инфляцтай тэмцэх Трампын бодлогыг 60–37-ийн харьцаагаар олон нийт шүүмжилж байна. Энэ асуудал нь Бүгд Найрамдах намын дунд хүртэл хамгийн сул дэмжлэгтэй сэдэв болж, ердөө 58% нь зөвшөөрч байна.

- Америкчуудын 57% нь АНУ одоогоор эдийн засгийн удаашралд орсон эсвэл удахгүй орох болно гэж үзэж байна. (Энэ нь 3-р сард 40% байсан үзүүлэлтээс эрс өссөн дүн юм.)
- Үүнээс 12% нь эдийн засгийн удаашрал аль хэдийн эхэлсэн гэж үзэж байна.

Төрийн зарлага, гадаад бодлого дээрх үнэлгээ мөн сөрөг:

- Төрийн зарлагын асуудлаар 51% нь Трампын бодлогыг эсэргүүцэж, 45% нь дэмжиж байна.
- Гадаад бодлогын хувьд 53% эсэргүүцэж, 42% нь дэмжсэн байна.

Ганц эерэг гэгээ: Хил хамгаалах ба цагаачлалын бодлого

Трампын хамгийн өндөр үнэлгээ авч буй салбар бол хил хамгаалах, цагаачлалын бодлого:

- Өмнөд хилийн хамгаалалтын бодлогыг 53–41%-ийн харьцаагаар дэмжиж байна.
- Албадан гаргалтын бодлогыг 52–45%-ийн харьцаагаар дэмжжээ.

Эдгээр асуудалд Трамп бие даагчдын дунд олонхийн дэмжлэг авч байгаа бөгөөд Ардчилсан намын 22%-ийн дэмжлэг авсан нь бусад асуудлуудаас хамгийн өндөр үзүүлэлт юм.

Хөрөнгийн зах зээлийн хандлага ч мууджээ:

- Одоо 38% нь хөрөнгө оруулахад таатай цаг гэж үзэж байгаа бол, 53% нь таагүй гэж үзэж байна. Энэ нь сүүлийн хоёр жилийн хугацаан дахь хамгийн сөрөг үзүүлэлт болов.
- 2024 оны 12-р сарын судалгаагаар хөрөнгийн зах зээлийн өөдрөг хандлага түүхэн дээд цэгт хүрч байсан билээ.



## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.04.14-04.20

### БНХАУ-ЫН ТӨВ БАНК БОДЛОГЫН ХҮҮГЭЭ ӨӨРЧЛӨЛГҮЙ ХАДГАЛЛАА

БНХАУ-ын Төв банк (PBOC) даваа гарагт зах зээлийн хүлээлттэй нийцүүлэн зээлийн суурь хүүгээ (Loan Prime Rate, LPR) тогтвортой хадгаллаа. Энэ нь Бээжингийн эдийн засгийн өсөлтийг дэмжих бодлого нь мөнгөний бодлогыг цаашид сулруулах бус, санхүүгийн бодлогоор түлхүү дэмжих чиглэлд шилжсэнийг харуулж байна.

Тухайлбал:

• **1 жилийн хугацаатай LPR-ыг 3.1%** түвшинд,

• **5 жилийн хугацаатай LPR-ыг** (ипотекийн зээлийн суурь хүү) **3.6%** түвшинд хэвээр хадгаллаа.

Эдгээр хүүгийн түвшин нь сүүлийн гурван жилд хийсэн хэд хэдэн бууралтын дараах түүхэн доод түвшинд үргэлжилж байна.

Зээлийн суурь хүү (LPR)-г PBOC сонгон шалгаруулсан 18 арилжааны банкны саналд үндэслэн тогтоодог бөгөөд улс орон даяар зээлийн хүүгийн жишиг үзүүлэлт болдог.

Гэсэн хэдий ч PBOC-ийн хувьд LPR-ийг цаашид бууруулах боломж хязгаарлагдмал болоод байна. Өмнөх бууруулалтууд эдийн засагт зөвхөн түр хугацааны дэмжлэг үзүүлсэн бөгөөд илүү үр дүнтэй эдийн засгийн сэргэлтийг хангахын тулд анхаарал санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх чиглэлд шилжжээ.

Энэ хүрээнд Хятадын эрх баригчид:


- Дотоодын хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор **нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг өргөжүүлэх**,
- **Өрхийн хэрэглээний бараанд зориулсан татаас** олгох зэрэг нэмэлт арга хэмжээнүүдийг санал болгосон байна.

### Эдийн засгийн өсөлт хүлээлтээс давлаа

2025 оны эхний улиралд Хятадын эдийн засаг **5.4%** өсөж, зах зээлийн хүлээлтээс давсан үзүүлэлт үзүүлээ. Энэхүү өсөлт нь дотоодын хэрэглээ сэргэсэн болон төрөөс эдийн засгийн гол салбаруудыг тогтворжуулахад чиглэсэн зорилтот арга хэмжээнүүд үр дүнгээ өгч эхэлсний илрэл юм.

### Гэсэн хэдий ч хөрөнгө оруулагчид болгоомжтой хэвээр байна

Эдийн засгийн өсөлтийн эерэг мэдээнүүдийг үл харгалзан хөрөнгө оруулагчид болгоомжтой хэвээр байна. АНУ-ын зүгээс сүүлийн үед Хятадын технологи болон үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүнд тавьсан тарифын нэмэлт хязгаарлалт нь Хятадын экспортод түшиглэсэн эдийн засагт ноцтой эрсдэл учруулж болзошгүй гэж үзэж байна.



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases for the week beginning April 14, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
<div>GS</div> <div>Goldman Sachs</div> <div>MTB</div> <div>M&amp;T Bank</div>	<div>APLD</div> <div>APPLIED BLOCKCHAIN</div> <div>FBK</div> <div>FirstBank</div> <div>PNFP</div> <div>Pinnacle Financial Partners</div> <div>SKIL</div> <div>skillsoft</div> <div>KMTS</div> <div>kestra MEDICAL TECHNOLOGIES</div> <div>OTRK</div> <div>ontrak health</div> <div>HIT</div> <div>hi+ health in tech</div> <div>BSEM</div> <div>BioStern TECHNOLOGIES</div>	<div>BAC</div> <div>BANK OF AMERICA</div> <div>C</div> <div>citi</div> <div>JNJ</div> <div>Johnson &amp; Johnson</div> <div>PNC</div> <div>PNC</div> <div>ACT</div> <div>Albertsons Companies</div> <div>ERIC</div> <div>ERICSSON</div> <div>RENT</div> <div>RENT THE RUNWAY</div> <div>ZBAO</div> <div>致保科技 Zhibao Tech</div>	<div>UAL</div> <div>UNITED</div> <div>IBKR</div> <div>Interactive Brokers</div> <div>JBHT</div> <div>J.B. HUNT</div> <div>HWC</div> <div>HUNTERDOGS</div> <div>FULT</div> <div>FULTON FINANCIAL CORPORATION</div> <div>EQBK</div> <div>EQUITY FINANCIAL GROUP, INC.</div> <div>KORE</div> <div>KORE</div> <div>GAME</div> <div>GAMESQUARE</div> <div>PSSI</div> <div>PIONEER POWER SOLUTIONS</div> <div>OMC</div> <div>Omnicom Group</div>	<div>ASML</div> <div>ASML</div> <div>USB</div> <div>us bancorp</div> <div>ABT</div> <div>Abbott</div> <div>PGR</div> <div>PROGRESSIVE</div> <div>TRV</div> <div>TRAVELERS</div> <div>PLD</div> <div>PROLOGIS</div> <div>MOV</div> <div>MOVADO GROUP INC</div> <div>ALV</div> <div>Autoliv</div> <div>CFG</div> <div>Citizens Financial Group, Inc.</div> <div>FHN</div> <div>FIRST HORIZON NATIONAL CORPORATION</div>	<div>AA</div> <div>Alcoa</div> <div>OZK</div> <div>Bank OZK</div> <div>HOMB</div> <div>HOMER</div> <div>CSX</div> <div>[CSX]</div> <div>KMI</div> <div>KINDER MORGAN</div> <div>SNV</div> <div>SYNOVUS</div> <div>GSBC</div> <div>GREAT SOUTHERN BANK</div> <div>REXR</div> <div>Rexford Industrial</div> <div>SLG</div> <div>Simmons Bank</div> <div>SLG</div> <div>SL GREEN REALTY CORP</div>	<div>TSM</div> <div>tsmc</div> <div>UNH</div> <div>UNITEDHEALTH GROUP</div> <div>HBAN</div> <div>Huntington</div> <div>AXP</div> <div>AMERICAN EXPRESS</div> <div>RF</div> <div>REGIONS</div> <div>TCB</div> <div>TEXAS CAPITAL BANK</div> <div>DHI</div> <div>D-R HORTON</div> <div>ALLY</div> <div>ally</div> <div>HFT</div> <div>HOOKER</div> <div>FIFB</div> <div>FIFTH THIRD BANK</div>	<div>NFLX</div> <div>NETFLIX</div> <div>MRTN</div> <div>MARTEN</div> <div>INDI</div> <div>INDEPENDENT BANK</div>				
http://eps.sh/cal								© 2025 Earnings Whispers			

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

E EARNINGS WHISPERS		Most Anticipated Earnings Releases <small>for the week beginning</small> April 21, 2025									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday			
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close
 <b>Capital City Bank</b>	 <b>AGNC</b> <small>INVESTMENT CORP.</small>	 <b>verizon</b>	 <b>TSLA</b> <small>TESLA</small>	 <b>BOEING</b>	 <b>O'Reilly AUTO PARTS</b>	 <b>American Airlines</b>	 <b>intel</b>	 <b>slb</b>			
 <b>DYNEX</b> <small>CAPITAL INC.</small>	 <b>Berkley</b>	 <b>GE Aerospace</b>	 <b>ENPHASE</b>	 <b>AT&amp;T</b>	 <b>Alaska AIRLINES</b>	 <b>NOKIA</b>	 <b>Alphabet</b>	 <b>abbvie</b>			
 <b>WASHINGTON TRUST FINANCIAL INC.</b>	 <b>AZZ</b>	 <b>LOCKHEED MARTIN</b>	 <b>INTUITIVE SURGICAL</b>	 <b>VERTIV</b>	 <b>CHIPOTLE</b> <small>RESTAURANT GROUP</small>	 <b>FRYBURY McDORMAN COPPER &amp; GOLD</b>	 <b>Celestica</b>	 <b>PHILIPS 66</b>			
 <b>Guaranty Bank &amp; Trust</b>	 <b>MEDPACE</b>	 <b>RTX</b>	 <b>SAP</b>	 <b>Amphenol</b>	 <b>servicenow</b>	 <b>Southwest</b>	 <b>T-Mobile</b>	 <b>SAIA</b>			
 <b>Comerica</b>	 <b>Metropolitan Commercial Bank</b>	 <b>DANAHER</b>	 <b>Capital One</b>	 <b>PHILIP MORRIS INTERNATIONAL</b>	 <b>IBM</b>	 <b>MERCK</b>	 <b>AGNICO EAGLE</b>	 <b>COLGATE-PALMOLIVE</b>			
 <b>HBT Financial</b>	 <b>BOK FINANCIAL</b>	 <b>Quest Diagnostics</b>	 <b>Steel Dynamics, Inc.</b>	 <b>NEXTERA ENERGY</b>	 <b>Newmont</b>	 <b>PEPSICO</b>	 <b>BOYD</b>	 <b>Portland General Electric</b>			
 <b>Bank of Hawaii</b>	 <b>FLEXSTEEL</b>	 <b>Elevance Health</b>	 <b>EAST WEST BANK</b>	 <b>CHECK POINT</b>	 <b>Lam RESEARCH</b>	 <b>DOW</b>	 <b>SKECHERS</b>	 <b>Lyondellbasell</b>			
	 <b>WINTRUST</b>	 <b>NORTHROP GRUMMAN</b>	 <b>RANGE RESOURCES</b>	 <b>GE VERNOVA</b>	 <b>CENTURY COMMUNITIES</b>	 <b>UNION PACIFIC</b>	 <b>PROSOMM HEALTH TRUST</b>	 <b>avantor</b>			
	 <b>Calix</b>	 <b>Kimberly-Clark</b>	 <b>Baker Hughes</b>	 <b>GENERAL DYNAMICS</b>	 <b>TEXAS INSTRUMENTS</b>	 <b>TRACTOR SUPPLY CO.</b>	 <b>VALE</b>	 <b>Charter COMMUNICATIONS</b>			
	 <b>Cathay Bank</b>	 <b>HALLIBURTON</b>	 <b>Manhattan ASSOCIATES</b>	 <b>VIRTU FINANCIAL</b>	 <b>Sands LAS VEGAS SANDS CORP.</b>	 <b>Valero</b>	 <b>Weyerhaeuser</b>	 <b>CENTENE Corporation</b>			
<a href="http://eps.sh/cal">http://eps.sh/cal</a>								© 2025 Earnings Whispers			